

**ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРОО /ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН
ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ЗАРИМ КОМПАНИУДЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ТАЙЛАНГ УЛСЫН ИХ ХУРАЛД ТАНИЛЦУУЛАХ ҮҮРЭГ БҮХИЙ/-НЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2023 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр, Даваа гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-2
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	3-5
<i>1. “Түр хорооны сонсгол товлон зарлах тухай” Хянан шалгах түр хорооны тогтоолын төсөл</i>	3-4

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Хянан шалгах түр хороо /Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн
оролцоотой зарим компаниудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, хяналт
шалгалтын тайланг Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий/-ны
11 дүгээр сарын 27-ны өдөр /Даваа гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Хянан шалгах түр хорооны дарга Б.Энхбаяр ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 11 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 32 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Ганбат, Т.Доржжанд;

Чөлөөтэй: М.Оюунчимэг;

Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Сүхбаатар.

Нэг. “Түр хорооны сонсгол товлон зарлах тухай” Хянан шалгах түр хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, мөн хэлтсийн референт М.Мандхай, Хяналт шалгалтын хэлтсийн зөвлөх Ж.Монголжингоо нар байлцав.

Хянан шалгах түр хорооны дарга Б.Энхбаяр “Түр хорооны сонсгол товлон зарлах тухай” Хянан шалгах түр хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Энхбаяр: “Түр хорооны сонсгол товлон зарлах тухай” Хянан шалгах түр хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 2

Бүгд: 6

66.7 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 11 цаг 36 минутад хэлэлцэж дуусав.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр дараагийн хэлэлцэх асуудал Хянан шалгах түр хорооны дотоод асуудал тул хуралдааныг хаалттай горимд шилжүүлэх горимын санал гаргав.

Б.Энхбаяр: Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 2

Бүгд: 6

66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул хуралдаан хаалттай горимд шилжлээ./11:38/

Хуралдаан 12 цаг 21 минутад нээлттэй горимд шилжив.

Хянан шалгах түр хорооны дарга Б.Энхбаяр өнөөдөр 13.00 цагаас тус хуралдаанаар хэлэлцсэн асуудлын талаар хэвлэлийн бага хуралтай тухай гишүүдэд мэдээлэв.

Хянан шалгах түр хорооны нээлттэй хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Нээлттэй хуралдаан 08 минут үргэлжилж, 11 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 63.6 хувийн ирцтэйгээр 12 цаг 23 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХЯНАН ШАЛГАХ ТҮР
ХОРООНЫ ДАРГА

Б.ЭНХБАЯР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр,
Даваа гараг
Төрийн ордон “Их засаг” танхим
11 цаг 32 минут.

ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Энхбаяр: Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой зарим компаниудын нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа болон бусад бараа, ажил, үйлчилгээ, худалдан авалтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, нотлох баримтыг шинжлэн судлах, нээлттэй сонсгол зохион байгуулах, иргэд, олон нийтийг мэдээллээр хангах, хяналт шалгалтын тайланг Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан танилцуулах үүрэг бүхий Хянан шалгах түр хорооны 2023 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдаан гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул нээснийг мэдэгдье.

Хуралдаанд оролцож байгаа гишүүдийн ирцийг танилцуулъя. Ирц, Бат-Амгалан гишүүн ирсэн байна, Ж.Бат-Эрдэнэ гишүүн ирсэн байна, С.Ганбаатар гишүүн ирсэн байна, Ганболд гишүүн ирсэн байна, Жаргалмаа гишүүн ирсэн байна, Энхбаяр гишүүн ирсэн байна.

Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 1.Хянан шалгах түр хорооны сонсголыг товлон зарлах тухай тогтоолын төсөл. 2.Хянан шалгах түр хорооны сонсголд гэрчээр дуудах тухай тогтоолын төсөл. 3.Нотлох баримтыг шинжлэн судлах, дараалал тогтоох тухай тогтоолын төсөл. 4.Нотлох баримтыг гаргуулах тухай 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 17 дугаар тогтоолд нэмэлт оруулах тухай тогтоолын төсөл гэсэн 4 асуудлыг тус тус хэлэлцэнэ. Хэлэлцэх

асуудал дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг. “Түр хорооны сонсгол товлон зарлах тухай” Хянан шалгах түр хорооны тогтоолын төсөл

Нэг.Хянан шалгах түр хорооны нотлох баримтыг шинжлэн судлах сонсголын товыг тогтоох тухай тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье. Та бүхэнд тогтоолын төслийг тараасан байгаа. Тогтоолын төслийг би уншиж сонсгоё. Тогтоолын төсөл хаана байна вэ, гаргаж байна уу? Түр хорооны сонсголыг товлон зарлах тухай Хянан шалгах түр хорооны тогтоолын төслийг уншиж сонсгоё. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэг, 36 дугаар зүйлийн 36.4 дэх хэсэг, 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсэг, 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Хянан шалгах түр хороо байгуулах тухай Монгол Улсын Их Хурлын 2023 оны 63 дугаар тогтоолоор байгуулагдсан Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооноос тогтоох нь:

1.Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой зарим компаниудын нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа болон бусад бараа, ажил, үйлчилгээ, худалдан авалтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, нотлох баримтыг шинжлэн судлах, нээлттэй сонсгол зохион байгуулах, иргэд, олон нийтийг мэдээллээр хангах, хяналт шалгалтын тайланг Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан танилцуулах үүрэг бүхий Хянан шалгах түр хорооны нотлох баримтыг шинжлэн судлах сонсголыг дараах 2 үе шаттайгаар зохион товлосугай.

Үүнд, Нэг.2023 оны 12 дугаар сарын 4-нөөс 8-ны өдрүүдэд Таван толгой хувьцаат компанийн нүүрс

олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа болон бусад бараа, ажил, үйлчилгээ, худалдан авалтын үйл ажиллагаа болон Эрдэнэс таван толгой хувьцаат компанийн нүүрс олборлолт бараа, ажил, үйлчилгээ, худалдан авалтын үйл ажиллагаа. Хоёр.2023 оны 12 дугаар сарын 18-наас 22-ны өдрүүдэд Эрдэнэс таван толгой хувьцаат компанийн нүүрс борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа, охин болон хараат компаниудын хөрөнгө оруулалт, тэдгээрийн үйл ажиллагаа.

Хоёр.Хянан шалгах түр хорооны нотлох баримтыг шинжлэн судлах сонсголыг товлосонтой холбогдуулан хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, сонсголын бэлтгэл, зохион байгуулалтыг хангаж ажиллахыг Хянан шалгах түр хорооны дарга Энхбаярт даалгасугай гэсэн тогтоолын төсөл байна. Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Түр хорооны сонсголыг товлон зарлах тухай, гишүүдээ дуудаарай. Түр хорооны сонсголыг товлон зарлах тухай тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 66,7 хувиар тогтоол батлагдлаа.

11.36 цаг

Дараагийн хэлэлцэх асуудал нь Түр хорооны дотоод асуудал учраас Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2, 12.3, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22.2 дахь хэсэгт заасныг үндэслэн хаалттай хуралдах горимын санал гаргаж байна. Горимын саналыг дэмжье гэдэг саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Жаргалмаа гишүүний микрофоныг өгье.

Б.Жаргалмаа: Хоцорч дарсан тул дэмжсэнээр тооцож өгнө үү.

Б.Энхбаяр: Жаргалмаа гишүүний саналыг дэмжсэнээр авъя. Хэдэн хувь болно гэсэн билээ, 66,7 хувиар горимын санал дэмжигдлээ. Дэмжигдсэн тул хуралдааныг хаалттай горимд шилжүүлбэ.

Хуралдаан 11 цаг 38 минутаас 12 цаг 21 минутад хаалттай горимоор үргэлжлэв.

Б.Энхбаяр: Хэлэлцэх асуудал дууссан тул хуралдааныг нээлттэй горимд шилжүүлж байна. Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой зарим компаниудын нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа болон бараа, ажил, үйлчилгээ, худалдан авалтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, нотлох баримтыг шинжлэн судлах нээлттэй сонсгол зохион байгуулах, иргэд, олон нийтийг мэдээллээр хангах, хяналт шалгалтын тайланг Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан танилцуулах үүрэг бүхий Хянан шалгах түр хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцсэн асуудлын талаар өнөөдөр 13 цагаас хэвлэлийн бага хуралтай. Хэвлэлийн бага хуралд Ганболд гишүүн оролцох уу? Ганболд гишүүн, Бат-Эрдэнэ гишүүн оролцох уу? Жаргалмаа гишүүн оролцох уу? Ганбаатар гишүүн, хуралтай байгаад байгаа. Бат-Амгалан гишүүн. Тэгвэл энэ сөрөг хүчнээс нэг ч гишүүн бас байхгүй л болох гээд байна. Энэ Цогтгэрэл гишүүн, хэн Ганболд гишүүн 2 байгаа юм болов уу? Ганбат гишүүн. Доржханд гишүүн чинь байхгүй байгаа, гадаад томилолттой, байхгүй байгаа юм уу? Цогтгэрэл гишүүн энэ одоо ядаж нэг сөрөг хүчнээс нэг гишүүн баймаар юм, тийм. Тийм үү, тэгвэл Цогтгэрэл гишүүнд хэлчхээрэй, юу 1 цагаас хэвлэлийн хуралд оролцооч гээд. Ингээд 13 цагаас хэвлэлийн хуралтай. Баярлалаа гишүүддээ.

Хуралдаан хаасныг мэдэгдье.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.УЯНГА*

